



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 5/173

Улаанбаатар хот

Ө.Болоржаргалыг төрийн албанаас чөлөөлж, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.3.7, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.2, 46.3, 46.5, 60 дугаар зүйлийн 60.1, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, 77.7.9, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 1.1, 2.2, 5.3, Татварын ерөнхий газрын даргын 2020 оны А/98 дугаар тушаалаар баталсан “Татварын улсын байцаагчийн эрх олгох, эрхийг хасах, хүчингүй болгох журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Татварын ерөнхий газрын харьяа Өмнөговь аймгийн татварын хэлтсийн Ханбогд сумын татварын тасгийн татварын улсын байцаагч Өөдөсийн Болоржаргал нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан тул 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон төрийн албанаас чөлөөлж, татварын улсын байцаагчийн эрхийг хүчингүй болгосугай.

2. Ө.Болоржаргалд олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 26,133,816 (хорин зургаан сая нэг зуун гучин гурван мянга найман зуун арван зургаа) төгрөгийг тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас тооцож олгохыг Өмнөговь аймгийн татварын хэлтэс (С.Дүүбаяр)-т зөвшөөрсүгэй.

3. Төрийн албан хаагчийг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлын санхүүжилтийг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Бямбадорж)-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Л.Нэргүй)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЗАЯАБАЛ